EY
Building a better working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**Шивээ овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

Бид **Шивээ Овоо ХК** (цаашид "Компани" гэх)-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

## Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь удирдлагын хариуцлага байдаг.

## Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаардаг. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан хязгаарлалттай дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.



A member firm of Ernst & Young Global Limited

EY
Building a better
working world

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Шивээ овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)**

---

**Хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл**

Санхүүгийн тайлангийн Тодруулга 3-д тодруулснаар, Компани уурхайн талбар ба түүнтэй холбогдох үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нөхөн сэргээхтэй холбогдон ирээдүйд гарах зардлуудаар Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 37 ("НББОУС 37") -ын дагуу сан байгуулах шаардлагатай. Нөхөн сэргээлтийн сан нь ирээдүйд гарахаар хүлээгдэж буй зардлуудын өнөөгийн үнэ цэнийг харуулж байх ёстой. Гэвч Компани 2013 болон 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх уурхайн нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг барагдуулах дэлгэрэнгүй үнэлгээг шинэчлэн хийгээгүй ба шаардлагатай уурхайн нөхөн сэргээлтийн санг бүртгээгүй байсан. НББОУС 37-ын шаардлагын улмаас гарах үр нөлөөг бид тооцоолох боломжгүй юм.

**Хязгаарлалттай дүгнэлт**

"Хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл" хэсэгт тайлбарласан асуудлын нөлөөллүүдийг эс тооцвол бидний дүгнэлтээр 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг СТОУС-уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Бусад зүйл**

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан нь 2014 оны 3 дугаар сарын 25-нд өөр аудитороор баталгаажигдсан бөгөөд тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Хязгаарлалттай дүгнэлт өгсөн шалтгаан нь 2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд хөрс хуулалтын хөрөнгийг СТОУТХ 20 - Ил Уурхайн Ашиглалтын Үеийн Хөрс Хуулалтын Өртөг-ийн шаардлагуудад нийцүүлэн тайлагнаагүй байсан. Тайлант жилд харьцуулагдах дүнгүүдэд тодорхой залруулгууд хийгдсэн ба дээрхтэй холбоотойгоор санхүүгийн тайлангын Тодруулга 13-т толилуулсан болно.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Шивээ Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

**ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

**ПЕТР МАРКИ**
Захирал

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2016 .02. 16



A member firm of Ernst & Young Global Limited

**ШИВЭЭ ОВОО ХК**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

| **ХӨРӨНГӨ** | **Тодруулга** | **2014 мян.төг** | **2013 мян.төг (Дахин тай-лагнасан*)** | **2012 мян.төг (Дахин тай-лагнасан*)** |
|---|---|---|---|---|
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 12 | 2,247,659 | 1,276,065 | 1,276,065 |
| Хөрс хуулалтын хөрөнгө | 13 | 13,224,557 | 8,536,828 | – |
| Үндсэн хөрөнгө | 14 | 59,351,842 | 53,746,544 | 53,280,240 |
| Биет бус хөрөнгө | 15 | 12,069 | 17,671 | 863 |
| Охин компанид оруулсан хөрөнгө Оруулалт | 16 | 530,131 | 380,131 | 380,131 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 10 | – | – | 65,301 |
| | | 75,366,258 | 63,957,239 | 55,002,600 |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | | |
| Урьдчилж төлсөн зардал ба бусад эргэлтийн хөрөнгө | 17 | 559,724 | 2,754,603 | 176,214 |
| Бараа материал | 18 | 11,117,046 | 12,163,273 | 11,129,139 |
| Дансны авлага | 19 | 3,984,274 | 1,858,529 | 2,035,238 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 20 | 1,121,415 | 3,216,340 | 971,665 |
| | | 16,782,459 | 19,992,745 | 14,312,256 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **92,148,717** | **83,949,984** | **69,314,856** |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР** | | | | |
| **Өөрийн хөрөнгө** | | | | |
| Энгийн хувьцаа | 21 | 1,341,900 | 1,341,900 | 1,341,900 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | | 1,984,188 | 226,686 | (3,494,389) |
| | | **3,326,088** | **1,568,586** | **(2,152,489)** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | | |
| Ажилчдын тэтгэврийн сан | 22 | 986,392 | 841,297 | 653,011 |
| Засгийн газрын тусламж | 23 | 25,950,111 | 29,480,815 | 31,462,125 |
| Санхүүгийн түрээсийн өглөг | 24 | 2,095,007 | – | – |
| Урт хугацаат зээл | 24 | 20,735,584 | 21,826,014 | 22,942,231 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 10 | 194,175 | 62,262 | – |
| | | 49,961,269 | 52,210,388 | 55,057,367 |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | | |
| Дансны болон бусад өглөг | 25 | 10,959,939 | 5,500,980 | 13,054,877 |
| Орлогын албан татварын өглөг | | 596,786 | 444,448 | – |
| Засгийн газрын тусламж | 23 | 3,530,704 | 3,809,683 | 3,355,101 |
| Санхүүгийн түрээсийн өглөг | 24 | 1,586,494 | – | – |
| Богино хугацаат зээл | 24 | 22,176,107 | 20,415,899 | – |
| Урьдчилж орсон орлого | 26 | 11,330 | – | – |
| | | 38,861,360 | 30,171,010 | 16,409,978 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **88,822,629** | **82,381,398** | **71,467,345** |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | **92,148,717** | **83,949,984** | **69,314,856** |

*Дахин тайлагнасан - 2014.03.25-нд гаргасан 2013 болон 2012 оны санхүүгийн тайлангийн дүнгүүдийг залруулсан болно. Дэлгэрэнгүйг тодруулга 32-оос харна уу.
Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ШИВЭЭ ОВОО ХК**

**ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**
**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

| | Тодруулга | 2014 мян.төг | 2013 мян.төг (Дахин тайлагнасан*) |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 4 | 36,163,584 | 31,608,061 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 5 | (29,027,120) | (23,392,648) |
| **Нийт ашиг** | | **7,136,464** | **8,215,413** |
| Бусад орлого | 6 | 4,456,854 | 4,376,552 |
| Удирдлагын зардал | 7 | (2,099,794) | (1,754,066) |
| Бусад зардал | 8 | (1,490,652) | (1,416,777) |
| **Нийт үйл ажиллагааны ашиг** | | **8,002,872** | **9,421,122** |
| Санхүүгийн зардал | 9,23 | (5,954,487) | (5,128,036) |
| **Татварын өмнөх ашиг** | | **2,048,385** | **4,293,086** |
| Тайлант жилийн орлогын албан татварын зардал | 10 | (158,970) | (444,448) |
| Хойшлогдсон орлогын албан татварын зардал | 10 | (131,913) | (127,563) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | | **1,757,502** | **3,721,075** |
| Нэгж энгийн хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашиг (нэгж хувьцаа/төгрөг) | 11 | 1,310 | 2,773 |

*Дахин тайлагнасан - 2014.03.25-нд гаргасан 2013 оны санхүүгийн тайлангийн дүнгүүдийг залруулсан болно. Дэлгэрэнгүйг тодруулга 32-оос харна уу.
Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ШИВЭЭ ОВОО ХК**

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

| | Энгийн хувьцаа мян.төг (Тод. 21) | Хуримтлагдсан ашиг мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|
| **2013 оны 1 дүгээр сарын 1-нд (Дахин тайлагнасан)** | 1,341,900 | (3,494,389) | (2,152,489) |
| Тайлант жилийн ашиг | – | 3,721,075 | 3,721,075 |
| **2013 оны 12 дугаар сарын 31-нд (Дахин тайлагнасан)** | 1,341,900 | 226,686 | 1,568,586 |
| Тайлант жилийн ашиг | – | 1,757,502 | 1,757,502 |
| **2014 оны 12 дугаар сарын 31-нд** | 1,341,900 | 1,984,188 | 3,326,088 |

*Дахин тайлагнасан - 2014.03.25-нд гаргасан 2013 оны санхүүгийн тайлангийн дүнгүүдийг залруулсан болно. Дэлгэрэнгүйг тодруулга 32-оос харна уу.
Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ШИВЭЭ ОВОО ХК**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

| | Тодруулга | 2014 мян.төг | 2013 мян.төг (Дахин тайлагнасан*) |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГАА** | | | |
| Татварын өмнөх ашиг | | **2,048,385** | **4,293,086** |
| *Тайлант хугацааны ашгийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус гүйлгээний залруулгууд* | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 14 | 3,765,650 | 3,358,672 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (олз) | .6 | (12,300) | 560 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз | 8 | 397,371 | – |
| Биет бус хөрөнгийн хорогдол | 15 | 5,602 | 4,099 |
| Хөрс хуулалтын хөрөнгийн шавхагдал | 13 | 552,975 | – |
| Найдваргүй авлагын нөөц | 7 | 48,975 | 31,608 |
| Ажилчдын тэтгэврийн зардал | 22 | 151,239 | 193,536 |
| Хүүний зардал | 9 | 5,954,487 | 5,128,036 |
| Хүүний орлого | 6 | (77,308) | (101,881) |
| Засгийн газрын буцалтгүй тусламжийн хорогдол | 23 | (3,809,683) | (3,355,101) |
| Валютын ханшийн бодит бус гарз (олз) | 8,6 | 394 | (1,319) |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг** | | **9,025,787** | **9,551,296** |
| *Ажлын капиталын өөрчлөлт* | | | |
| Дансны авлагын (бууралт) | 19 | (2,174,720) | 145,101 |
| Урьдчилж төлсөн зардал болон бусад авлагын бууралт (өсөлт) | 17 | 1,223,286 | (2,578,389) |
| Бараа материалын бууралт (өсөлт) | 18 | (2,134,233) | 6,578,704 |
| Дансны болон бусад өглөгийн өсөлт (бууралт) | 25 | 5,458,959 | (5,725,524) |
| Урьдчилж орсон орлогын өсөлт | 26 | 11,330 | – |
| *Үйл ажиллагаанаас орсон мөнгөн урсгал* | | 11,410,408 | 7,971,188 |
| Хүлээн авсан хүүний орлого | 6 | 77,308 | 101,881 |
| Ажилчдын тэтгэвэр төлөлт | 22 | (6,144) | (5,250) |
| Орлогын албан татвар төлөлт | 10 | (6,632) | – |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **11,474,940** | **8,067,819** |

(Үргэлжлэлийг 9-р хуудаснаас харна уу.)

*Дахин тайлагнасан - 2014.03.25-нд гаргасан 2013 оны санхүүгийн тайлангийн дүнгүүдийг залруулсан болно. Дэлгэрэнгүйг тодруулга 32-оос харна уу.
Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.